

ЯПОН ОРОСЫН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА

У.Загдцэсэм*

Хүйтэн дайны үе дуусч, дэлхий дахины олон улсын харилцаанд ноёрхож байсан хоёр туйлт тогтолцооны халааг олон туйлт тогтолцоо өвлөн авлаа. Их гүрнүүдийн бодлогод өөрчлөлт гарч, улс орнуудын хоорондын үзэл суртлын сөргөлдөөн ариллаа. Улс хоорондын харилцаа хэвийн болох хандлагад шилжин, улмаар бие биеэс ялгаатай улс гүрнүүд хоорондоо ойртох, хамтын ажиллагаа, түншлэлийн эрин үе ирж байгаа нь ажиглагдах болов.

Энэ бодит үйл явц хэдэн арван жилийн турш эсрэг тэсрэг хоёр системийн толгойлогч гол гишүүн орны байр суурийг эзэлж, системийнхээ эрх ашгийн үүднээс бие биедээ хандсаар ирсэн Япон Оросын харилцаанд зохих нөлөөгөө үзүүлээ. Энэ хоёр орны талаар харьцуулсан мэдээг хүснэгтээр үзүүлбэл

	Япон Улс	Оросын Холбооны Улс
Газар нутаг	380 мянган км ²	17 сая 80 мянган км ²
Дундаж наслалт, дэлхийд эзлэх байр. /Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. 2000 он/	74,5 1-р байр	61,3 91-р байр
Хэрэглээний үнэ өндөр хот, дэлхийд эзлэх байр.	Токио 1-р байр Осака 2-р байр	Москва 5-р байр Санкт-Петербург 8-р байр
GNP /1999 он/	4789 тэрбум доллар	332,5 тэрбум ам.дол
Нэг хүнд оногдох GNP /1999 он/	32230 ам.дол	2,270 ам.дол
Засгийн газрын төсвийн хэмжээ	472,5 тэрбум ам.дол	38,9 тэрбум ам.дол
Дэлхийн худалдаанд эзлэх байр /1995 он/	3-р байр /7,73%/	20-р байр /1,23%/
Япон Оросын худалдаа /2000 он/ Худалдааны нийт эргэлт 3 тэрбум 338 сая доллар.	Экспорт 572 сая ам.дол Импорт 2 тэрбум 766 сая ам.дол	Экспорт 2 тэрбум 766 сая ам.дол Импорт 572 сая ам.дол

ийм байна¹.

Дэлхийн улс төр, олон улсын харилцааны өөрчлөлт хувьслын өнөө үед хөрш хоёр их гүрэн Япон, Оросын харилцаанд дэвшилт хандлагууд гарсаар байна.

Юуны өмнө, улс төрийн харилцааны салбарт ОХУ-ыг Том долоогийн гишүүнд албан ёсоор хүлээн зөвшөөрөх санаачлагыг дэмжихэд Япон улс идэвхтэй үйл ажиллагаа явуулж, улмаар 1993 оны Том долоон гүрний уулзалтыг Япон улс удирдан зохион байгуулсан

*У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

юм². Чухам энэ уулзалтаар ОХУ дэлхийн хөгжингүй 7 гүрний эгнээг өргөжүүлж, 8 дахь орон болсон зэрэг нь Япон Оросын харилцааны хөгжилд жинтэй түлхэц үзүүлсэн төдийгүй нутаг дэвсгэрийн асуудлын царцанги байдлыг ч хөдөлгөөнд оруулах оновчтой дипломат ажиллагаа болсон гэдгийг томоохон хэвлэлүүдэд тухайн үед цохон тэмдэглэж байв.

1997 оны тавдугаар сарын 16-18-ны өдрүүдэд ОХУ-ын Батлан хамгаалах Яамны сайд И.Родионов Японд албан ёсны айлчлал хийжээ. Айлчлалынхаа үеэр Япон, Америк хоёр улс аюулгүй байдлын тогтолцоогоо бэхжүүлж байгаа явдалд нааштай хандаж, дэмжиж байгаагаа мэдэгджээ.

Мөн оны зургадугаар сарын 20-ны өдөр Америкийн Дэнвер хотод Японы Ерөнхий сайд Рюүтаро Хашимото, Оросын Ерөнхийлөгч Борис Ельцин нар уулзаж цаашдаа жилд нэг удаа харилцан айлчилж байхаар тохиролцов. Япон улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орон болох эрмэлзлэлийг ОХУ дэмжихээ Ерөнхийлөгч Б. Ельцин анх мэдэгджээ.

1997 оны долдугаар сарын 24-ны өдөр Японы Ерөнхий сайд Р.Хашимото Орост хандах гадаад бодлогынхоо шинэ чиг шугамыг цаашид Япон, Оросын харилцааны сайжирлыг итгэлцэл, харилцан ашигтай байдал, алсын ирээдүйг зорьсон үзэл баримтлах гэсэн гурван үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэхээ мэдэгдэж, “хүйтэн дайны” үеийн Орост хандах гадаад бодлогын үндсэн чиг баримтлалаас салж, хоёр талын эрх ашигт нийцсэн арга замыг баримтлах болно гэдгээ тодорхойлов³. Үүнээс өмнөх Япон, Оросын харилцаа хойд нутаг дэвсгэрийн маргаанаас болж зөвхөн энэ асуудлыг тойрон гацаж, тун хомсхон хэмжээтэй байсан бөгөөд цаашид харилцааг өргөжүүлэхэд голлон анхаарах санал тавьсан юм. Үүний дараа Оросын Ерөнхийлөгчийн мэдээллийн албаны дарга Ерөнхийлөгч Борис Ельцин Японы шинэ чиг бодлогыг дэмжиж байгааг мэдэгджээ.

1997 оны арваннэгдүгээр сарын 1-2-ны өдөр ОХУ-ын Красноярскт түүний хойтон жил 1998 оны дөрөвдүгээр сарын 18-19-ний өдөр Японы Кавана-д ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин Японы засгийн газрын ерөнхий сайд Р.Хашимото нарын албан ёсны бус уулзалт хэрэгжин 1993 оны “Токиогийн тунхаглал”-д тулгуурлаж “2000 он гэхэд хоёр орны хооронд энх тайвны гэрээ байгуулахад бүх хүчээ дайчлах болно” гэж санал нэгтгэйгээр шийдэв. Эдгээр уулзалт нь хоёр орны хооронд итгэлцлийн уур аьсгалыг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон юм.

1997 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдөр Оросын Гадаад явдлын Яамны сайд Е.Примаков Японд айлчилж, Японы Гадаад хэргийн сайд К.Обүчитэй уулзжээ. Хоёр улсын Гадаад хэргийн сайд нарын энэ уулзалтаар энх тайвны гэрээ байгуулах асуудал эрхлэх хэлэлцээрийн шинэ бүтцүүдийг байгуулж, тэдгээрийг Гадаад явдлын Яамны сайд нар тэргүүлэхээр тохиролцжээ.

Дээрх уулзалтуудын дараах шатны томоохон үйл явдал бол 1998 оны арваннэгдүгээр сард Япон улсын засгийн газрын Ерөнхий сайд К.Обүчи -гийн ОХУ-д айлчилсан айлчлал болсон юм. Энэ айлчлалаар улс төрийн яриа хэлэлцээ явагдаж, ОХУ-ын Ерөнхийлөгч, Японы Ерөнхий сайд нар “ОХУ, Япон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай Москвагийн тунхаглал”-д гарын үсэг зурж, “Хоёр улсын удирдагчид 2000 онд багтаан энх тайвны гэрээ байгуулахад бүх хүчээ дайчлан ажиллах болно гэдгээ дахин нотолсон юм”.

1998 онд Япон Оросын эдийн засгийн хорооны Алс Дорнодын хэсгийн хуралдаан болж Зарубино боомтыг өргөтгөх, Средне Якутскийн хооронд хийн хоолой барих, Буреагийн усан цахилгаан станцийг байгуулах гэх зэрэг 13 төслийн талаар авч хэлэлцжээ⁴.

2000 оны дөрөвдүгээр сард Иркутскт Оросын Ерөнхийлөгч В.Путин, Японы Ерөнхий сайд И.Мори нар уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын тулгамдсан асуудлуудаар санал солилцсон бөгөөд энх тайвны гэрээ байгуулах талаарх яриа хэлэлцээг цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй гэж санал нэгдсэн юм⁵. Энэхүү уулзалт нь хоёр орны цаашдын харилцаанд чухал үйл явдал болсон юм. Уулзалтын үеэр хамтарсан мэдэгдэл гаргасан бөгөөд уг мэдэгдэлдээ хоёр орны худалдаа, эдийн засгийн хүрээн дэх хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхийн чухлыг дурдсан юм. 2000 оны есдүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Японд айлчилсан явдал хоёр орны харилцааны хөгжилд онцгой чухал үйл явдал болсон юм. Энэ айлчлалын үеэр Японы тал Орос улсыг Олон улсын худалдааны байгууллагад гишүүнээр элсэх, мөн АСЕАН-ы орнуудын эгнээнд нэгдэн ороход тус тус дэмжинэ гэж мэдэгдсэн юм⁶. Мөн Оросын тал Япон улстай удаан хугацааны бүтээлч хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа нотолсон юм. Энэ айлчлал Орос, Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад ихээхэн хүчин түлхэц боллоо.

2003 оны нэгдүгээр сард Японы засгийн газрын Ерөнхий сайд Ж.Коизуми Оросын Холбооны Улсад албан ёсны айлчлал хийлээ. Япон

Улсын Засгийн газрын тэргүүний Оросод хийсэн айлчлал 1956 оны Хатоямагийн айлчлалаас хойш, 1973, 1996 онд болж байжээ. Энэ удаагийн айлчлалын үеэр дэлхий дахины олон улсын харилцааны хандлагын асуудал, бүс нутгийн аюулгүй байдал, БНАСАУ, Иракийн асуудлаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй өргөн хүрээнд улс төрийн яриа хэлэлцээ хийсэн нь олон улсын асуудлаар Орос, Японы хооронд хамтын ажиллагаа өргөжиж байгааг харуулж байна. Нөгөө талаар Япон улс өнгөрсөн оноос БНАСАУ-тай харилцааг хэвийн болгох талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хойд Солонгост ОХУ-ын зүгээс үзүүлж чадах хүчирхэг нөлөөг тооцоолсон нь мэдээж юм.

Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр Орос Японы эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр 15 гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан билээ. Дээрх гэрээ хэлэлцээрүүд хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид бататган хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Оростой эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх Японы стратегийн гол сонирхол нь Оросын Алс Дорнод, Сибирийн байгалийн нөөцийг хамтран ашиглахад чиглэж байна. Оросын тал ч үүнийг дэмжиж хамтран ажиллах асуудалд нэлээд ач холбогдол өгч байна. Хоёр тал “Орос-Японы” эрчим хүчний гүүр байгуулах асуудлыг ихээхэн чухалчлах болов. Оросоос Японд эрчим хүч экспортлоход чиглэсэн төслийн нэг нь Сахалины арлаас далай доогуур байгалийн хий, нефть дамжуулах хоолой татах томоохон төсөл юм. Төслөөр бол далай доогуур эхлээд томоохон хэмжээний хонгил бариад дараа нь тэр хонгилоор хурдан галт тэрэг зорчиж Транссибирийн төмөр замтай холбогдсоноор Япон, Европийн хооронд хурдан галт тэрэг зорчих боломж бүрдэхээс гадна нефть хийн хоолойг ч түүнийг ашиглан барьж байгуулахаар тооцжээ. Япон Оросын хамтын ажиллагааны ирээдүй ийм өөдрөг төсөөлөлтэй байгаа ч өнөөгийн бодит амьдрал дээр хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа туйлын хангалтгүй байгаа. Оросын гадаад худалдааны эргэлтийн дөнгөж нэг хувийг Японтой хийж байна. Японы гадаад худалдаанд Оросын эзлэх хувь мөн нэгэн адил үлэмж доогуур буюу 3%-г эзэлж байна⁷. Япон улс Оросоос импортлож буй бараа бүтээгдэхүүний 90 орчим хувь нь түүхий эд материал, металл, гуалин, нүүрс, далайн амьтдаар хийсэн хүнсний бүтээгдэхүүн эзлэнэ. Орос, Японоос өнөөгийн байдлаар гол төлөв үйлдвэрийн суурь машин, ачааны болон суудлын авто машин, электроникийн тоног төхөөрөмж импортлож байна.

Орост орсон гадаадын нийт хөрөнгө оруулалтын хувь хэмжээний дотор ч Япон мөн л төдийлөн дээгүүрт орохгүй. 2000 оны байдлаар, Япон улс Орост нийтдээ 336 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийжээ. Энэ нь Орост хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хөрөнгө оруулагчдын дотор Япон улс IX байранд явж байна гэсэн үг юм. Үүний дотор Японы шууд хөрөнгө оруулалт 141,3 сая ам. доллар байгаа аж. Мөн оны байдлаар Япон Оросын хамтарсан хөрөнгө оруулалттай 380 аж ахуйн нэгж Орост үйл ажиллагаа явуулж байгаагийн 300 нь Алс Дорнодод байршдаг аж⁸.

Япон Оросын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж болох алс хэтийн асар их ирээдүйтэй, нөөц боломжтой салбарын нэг бол загас агнуур юм. Энэ чиглэлд хоёр тал сүүлийн үед ихээхэн ач холбогдол өгч яриа хэлцэл хийж байна.

Ерөнхий сайд Ж.Коизүми энэ оны нэгдүгээр сард ОХУ-д хийсэн айлчлалынхаа хүрээнд Оросын Алс Дорнодын Хабаровскт айлчилсан нь Япон болон ОХУ-ын Алс Дорнодын эдийн засгийн хамтын ажиллагаа, хүн солилцоог хөгжүүлэхэд чухал эхлэл боллоо. ОХУ-д хийсэн айлчлалын үеэр Ерөнхий сайд Коизүми Сахалин төсөлд Японы талаас оруулж буй хувь нэмрийн талаар, Япон улсаас Сахалин 1, 2 төсөлд 1 тэрбум долларын хөрөнгийг нэгэнт оруулаад байгаа бөгөөд, Сахалинийг хөгжүүлэх төсөлд зарцуулах нийт 22 тэрбум долларын 8 тэрбум долларыг Японы талаас гаргахаар шийдвэрлэснийг цохон тэмдэглэсэн юм⁹.

Ийнхүү Орос улсын нийт газар нутгийн гуравны нэгийг эзэлж, хүн амын дөнгөж 5% нь оршин сууж байгаа Алс Дорнодын бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх хөрөнгө, ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэхэд Японы нөөц боломжийг ашиглахад хоёр талын сонирхол төвлөрч байгаа.

Нөгөө талаар Оросын нефть, эрчим хүчний баялаг нь бүс нутгийн орнууд Хятад, Японы анхаарлыг татаж, хамтын ажиллагааны боломжийг бий болгож байна.

Дайнаас хойш ЗХУ-ыг задрах хүртэл Япон ЗХУ-ын харилцаа ихээхэн төвөгтэй байсан бөгөөд Зөвлөлт-Японы хооронд дайны байдлыг зогсоож хэвийн дипломат харилцаа тогтоосон хамтарсан тунхагт гарын үсэг зурснаас хойш 47 жил өнгөрч байгаа боловч тус хоёр хөрш гүрний хооронд энх тайвны гэрээ байгуулагдажгүйгээр өнөөг хүрлээ. Энэ нь Япон Оросын хооронд байсан, байсаар байгаа газар нутгийн асуудалтай шууд холбоотой юм. Япончууд “хоппоо рёодо” буюу

“хойд газар нутаг” хэмээн нэрлэдэг өмнөд Курилын арлууд болох Хабомай (102 кв.км), Шикотан (225 кв.км), Эторуп (1,138 кв.км), Күнашир (1,500 кв.км) дөрвөн арлын асуудал юм. Өнөөдөр хоёр улсын хооронд энх тайвны гэрээ, хэвийн улс төр, эдийн засгийн хэлхээ холбоог өргөжүүлэн хөгжүүлэхэд энэхүү шийдэгдээгүй байгаа газар нутгийн асуудал саад болсоор байна.

Газар нутгийн асуудлыг шийдвэрлэж байж сая Япон Оросын харилцаа чанарын шинэ түвшинд дэвшин гарах боломж бий болно хэмээн Япон улсын зүгээс сүүлийн үед дипломат шугамаар онцлон тэмдэглэж ирлээ. Нутаг дэвсгэрийн маргааныг шийдвэрлэхийн тулд юуны өмнө Япон Оросын харилцаа, хамтын ажиллагаа юугаараа чухал болох, хамтын ажиллагааны хөгжлийн далд нөөц боломж юу байгаа зэргийг хоёр тал харилцан бүрэн ойлгосон байх хэрэгтэй байна хэмээн Японы тал үзэж байна.

Нутаг дэвсгэрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд **Нэгдүгээрт** Япон Оросын бүх талын хамтын ажиллагааг улам хөгжүүлэх; **Хоёрдугаарт** улс төрийн лидерүүдийн найрсаг дотно, харилцан итгэлцсэн харилцааг бэхжүүлэх; **Гуравдугаарт** нутаг дэвсгэрийн асуудлын талаарх олон нийтийн санаа бодлыг судлах, хоёр орны ард түмний харилцаа хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэхийн чухлыг ард түмэнд бүрэн ойлгуулах; **Дөрөвдүгээрт** олон улсын түүхэнд аливаа нутаг дэвсгэрийн асуудлыг хэрхэн авч үзэж ирсэн, орчин үед нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж буйг харгалзан үзэх гэх мэтийн олон хүчин зүйлс байж болохыг Японы хэвлэлд тэмдэглэж байна¹⁰.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Япон Оросын харилцааны хөгжлийг харахад Хятад Оросын харилцаатай харьцуулбал илэрхий хоцрогдонгуй явж ирлээ. 2000 онд багтаан найрамдлын гэрээ байгуулахаар тогтсон Красноярскийн тохиролцоо амьдралд хэрэгжилгүй өнгөрөв. Ерөнхийлөгч В.Путины хувьд ч Хабомай, Шикотан хоёр арлыг Японд буцаахаар тохиролцсон 1956 оны Япон Оросын хамтарсан тунхаглалын үзэл санаанаас хэтрүүлж буулт хийхгүй нь тодорхой.

2003 оны арванхоёрдугаар сард Оросын ДУМ-ын сонгууль, 2004 оны гуравдугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль явагдах гэж буй ийм үед хэдэн арван жилийн турш эрчимтэй явуулсан Зөвлөлтийн суртал нэвтрүүлгийн үрээр Оросын нутаг дэвсгэр хэмээн итгүүлж чадсан хойд нутгийн 4 арлыг найр тавин буцааж гарын үсэг зурах улс төрийн удирдагч гарч ирнэ гэхэд эргэлзээтэй.

2003 оны нэгдүгээр сард Японы Улсын засгийн газрын Ерөнхий сайд Ж.Коизүмигийн ОХУ-д хийсэн айлчлалын үеэр хоёр улсын төр, засгийн тэргүүн нарын түвшинд болсон улс төрийн яриа хэлэлцээгээр газар нутгийн асуудлыг шийдвэрлэх талаар хөндөөгүй бололтой.

Шинэ XXI зууныг хүртэл өвлөгдөн хоцорсон хойд нутаг дэвсгэрийн асуудал мухардалд орж, Япон Оросын хоорондын улс төрийн харилцаанд хүйтэн уур амьсгал хадгалагдсан хэвээр байна. Оросын талын хувьд хүйтэн дайны үеийн сөрөг уур амьсгал арилсан хэдий боловч Орос улсын гадаад бодлогын өргөн орон зайд Япон улс чухам хаана нь явна вэ гэдэг асуудлын тухайд одоогоор тодорхой хариулт алга. Оросын олон нийт Японы эдийн засгийн олон жилээр ужгирч ирсэн уналтыг анхааралтай ажиглаж, Японы хөрөнгө оруулалт Алс Дорнодод цаашид нэмэгдэнэ гэдэгт найдах найдвар нь суларч байна. Юу боловч Оросын Холбооны дорнод хэсгийн дэд бүтэц, бизнесийн орчны нөхцөл тийм ч ашигтай биш байна. Гэвч сүүлийн үед Оросын засгийн газар Хойд Солонгостой харилцааг хэвийн болгохын төлөө явуулж буй Японы үйл ажиллагааг дэмжиж Японы засгийн газартай харилцаагаа улам гүнзгийрүүлэх эрэл хайгуул хийж эхэллээ.

Дүгнэж хэлэхэд, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нөөц боломжтой. Энэхүү нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглахад гол саад болж буй зүйл бол бид бүхний сайн мэдэх газар нутгийн асуудал юм. Судлаачид улс төрийн харилцаа хоёр орны эдийн засаг, худалдааны харилцаанд саад болж таарахгүй гэж үзэж байгаа хэдий ч амьдрал дээр энэ л асуудал саад болсоор байна.

Энэ хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны цаашдын өрнөл хөгжилт нь бүс нутгийн эдийн засгийн интеграци ямар хурдтай, хэрхэн өрнөхийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн дотроос магад ч үгүй шийдвэрлэх хүчин зүйлийн нэг байж болох юм.

Ишлэл зүүлт

1. Imidas 2002. Japan. 2002. х. 517
2. Гаико форум-2003, х. 28
3. North east Asian Study, Series in Japan. 2001. №4, х. 20
4. Гаико форум-2003, х. 25
5. М.Галузин. Необходим откровенный диалог с Японией. Международная жизнь. №6, с-17, 2001

6. О.Добринская. Отношения Японии с крупными державами АТР. Мировая экономика и международные отношения. №8, с-99, 2003
7. Монгол улс ба Зүүн хойт Ази. 2002, УБ, х. 66-67
8. Мөн тэнд
9. Гаико форум-2003, х. 23
10. Гаико форум-2003, х. 28